



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/284

Есөнбулаг сум

Төрийн болон албаны нууцтай
танилцах эрхийн зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.2, 22.1.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дахь хэсэг, Төрийн болон албаны нууц хамгаалах журмын 4 дүгээр 4.1, 4.2, 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон албаны нууцтай танилцах аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн эрх бүхий албан тушаалтнуудад хариуцсан ажил, албан үүргийн хүрээнд Төрийн болон албаны нууцтай танилцах эрхийн зэрэглэлийг харгалзан нууцтай танилцах эрхийн зөвшөөрлийг хавсралтаар олгосугай.

2.Төрийн болон албаны нууц хамгаалах тухай хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг нууцтай танилцах эрхийн зөвшөөрөл олгосон эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 22-ны өдрийн 41 дүгээр
захирамжийн хавсралт

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦТАЙ ТАНИЛЦАХ
ЭРХИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН АЛБАН ХААГЧДЫН ЖАГСААЛТ

№	Овог нэр	Албан тушаал	Нууцтай танилцах эрхийн түвшин
1	Д.Эрдэнэжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Хоёрдугаар түвшин
2	Б.Пүрэвбаатар	Хэвлэл мэдээлэл, мэдээлэл технологи, цахим засаглал сүлжээний аюулгүй байдлын бодлого хариуцсан мэргэжилтэн	Гуравдугаар түвшин
3	Ү.Отгонзаяа	Төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн	Хоёрдугаар түвшин
4	М.Мөнгөнбаяр	Төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн	Хоёрдугаар түвшин

_ оОо _

